

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн
А-151 дугаар тушаалын хавсралт

БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

- 1.1 Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг банкны хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашигт нийцүүлэх, улмаар банкны зохистой засаглалын тогтолцоог боловсронгуй болгоход энэхүү журмын зорилго оршино. Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) баталсан “Компанийн засаглалын зарчим”-ыг удирдлага болгоно.
- 1.2 Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - “Хадгаламж эзэмшигч” гэж Иргэний хуулийн 454.1-д заасны дагуу мөнгөн хадгаламжийн гэрээгээр банкинд мөнгөө хадгалуулсан этгээдийг;
 - “Харилцагч” гэж Иргэний хуулийн 445.1-д заасны дагуу төлбөр тооцооны гэрээгээр банкаар бэлэн болон бэлэн бусаар төлбөр тооцоо гүйцэтгүүлж буй этгээдийг;
 - “Хувьцаа эзэмшигч” гэж Компанийн тухай хуулийн 3.2-т тодорхойлсон хувьцааг эзэмшсэнээр 3.3-т заасан эрх эдэлдэг этгээдийг;
 - “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж Компанийн тухай хуулийн 89-т тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээд 89.1-д заасан харилцаанд оролцсоныг;
 - “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 89.2-т тодорхойлсон этгээдийг;
 - “Томоохон харилцагч”- тухайн банкнаас болон Монголбанкнаас томоохон харилцагч, эзэлдэгч, хадгаламж эзэмшигч гэж үзсэнийг.

ХОЁР. Хувьцаа эзэмшигч

- 2.1 Хувьцаа эзэмшигч банкны үйл ажиллагаатай холбоотой Компанийн тухай хуульд заасан мэдээллийг зөвхөн ТУЗ-өөр дамжуулан гаргуулан авах эрхтэй.

- 2.2 Хувьцаа эзэмшигч нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай болон Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:
- 2.1.1 Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх;
- 2.1.2 Банкны хувьцааны эцсийн өмчлөгч, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон бүртгэлийг холбогдох баримт бичгийн хамт Монголбанкинд мэдээлэх.
- 2.2 Хувьцаа эзэмшигч банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:
- 2.1.1 Банкны тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч банкны гүйцэтгэх удирдлагад ажиллах;
- 2.2.1 Хувийн ашиг сонирхлын үүднээс эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах.
- 2.3 Хувьцаа эзэмшигч зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх хэлбэрээр банкны үйл ажиллагаанд оролцоно.
- 2.4 Хувьцаа эзэмшигч нь хуульд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах, өөрийн эзэмшлийн хувьцааг буцаан худалдан авахыг шаардах эрхтэй.

ГУРАВ. Банкны төлөөлөн удирдах зөвлөл

- 3.1 ТУЗ нь Банкны тухай хуулийн 31.3.7 дахь заалтыг хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагаа, төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдалд хариуцлага хүлээх үндсэн нэгж байна.
- 3.2 ТУЗ-ын дарга банкыг удирдах үйл ажиллагаанд ТУЗ-ын хуралд санал өгөх хэлбэрээр оролцохоор хязгаарлагдана.
- 3.3 ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.
- 3.4 ТУЗ нь Компанийн тухай болон Банкны тухай хуульд зааснаас гадна дараах эрхтэй:
- 3.4.1 ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журмыг батлах;
- 3.4.2 Банкны Гүйцэтгэх удирдлага болон бусад шийдвэр гаргах шатны эрх бүхий албан тушаалтнаас дараах асуудлаар тайлбар гаргуулан авах:
- 3.4.2.1 Холбогдох хууль тогтоомжид заасан зохистой харьцаа, хязгаарлалтыг зөрчиж хийсэн ажил гүйлгээ;
- 3.4.2.2 Банкны хяналтын багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигч, банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, үүнтэй холбоотойгоор үүссэн эрсдэл;
- 3.4.2.3 Банкны санхүү, төлбөрийн чадварын тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэх ажил гүйлгээ.

- 3.4 ТУЗ нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай болон Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:
- 3.4.1 Банкны Гүйцэтгэх удирдлагад хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, Хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
 - 3.4.2 Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашгийг хамгаалах;
 - 3.4.3 Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
 - 3.4.4 Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 3.4.5 ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг дүгнэх;
 - 3.4.6 Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрт тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
 - 3.4.7 Гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
 - 3.4.8 Хууль тогтоомж болон банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
 - 3.4.9 Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
 - 3.4.10 Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
 - 3.4.11 Банкны дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
 - 3.4.12 Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.
- 3.5 ТУЗ нь банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:
- 3.5.1 ТУЗ-ийн гишүүн, түүний холбогдох этгээдийн тухайн банкнаас авсан зээл, зээлтэй адилтган тооцох актив, баталгаа, батлан даалтаар хүлээсэн аливаа

үүрэг, өр төлбөрийн ангилал Монголбанкнаас тогтоосон журмын дагуу анхаарал хандуулах болон чанаргүй болсон бол тохиолдолд уг гишүүнийг банкны удирдах үйл ажиллагаанд оролцуулах;

3.5.2 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

3.5.2.1 Аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хорооны гишүүн байх;

3.5.2.2 Гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхтэй оролцох;

3.5.2.3 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх.

3.6 Банкны ТУЗ-ийн дарга нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Банкны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.6.1 Тухайн асуудлаар шийдвэр гаргахад ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүгнэлтийг үндэслэх;

3.6.2 ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.6.3 ТУЗ-ийн гишүүнийг зохистой засаглалын сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг батлан гаргаж, хэрэгжүүлэх.

3.7 ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшуулын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй байна.

3.8 Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай болон Банкны тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.1 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих;

3.8.2 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;

3.8.3 Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;

3.8.4 ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

3.8.5 Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжийг зөрчих

тохиолдол бүрт Монголбанкинд мэдэгдэх, улмаар хүсэлт гарган банканд шалгалт хийлгэх;

3.8.6 ТУЗ-ийн хараат бус гишүүн тус бүр нь өөрийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажлын тайлан зэргийг Монголбанкинд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах;

3.9 ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлэх үүднээс хороодыг байгуулж, хороод нь дараах чиг үүргийн дагуу тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-ын хуралд танилцуулна:

3.9.1 Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо:

3.9.1.1 Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

3.9.1.2 Банкны гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавих;

3.9.1.3 Дотоод аудитын албанаас банкны эрсдэлийн удирдлагад хийсэн аудитын шалгалтын акт, материалтай тухай бүр танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах;

3.9.1.4 Санхүүгийн хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан эсэхэд хяналт тавих;

3.9.1.5 Бусад холбогдох асуудал.

3.9.2 Аудитын асуудал эрхэлсэн хороо:

3.9.2.1 Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-д танилцуулж буй санхүүгийн тайлан, мэдээ нь үнэн зөв, бүрэн гүйцэд боловсруулсан эсэхэд хяналт тавих;

3.9.2.2 Аудитын бодлого, дүрэм журмын хэрэгжилт, аудитын төлөвлөгөөний биелэлт болон шалгалтын удирдамжийн агуулгад хяналт тавих;

3.9.2.3 Хөндлөнгийн болон дотоод аудитын асуудлыг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хариуцан ажиллах;

3.9.2.4 Дотоод аудитын нэгжийн бие даасан, хараат бус байдал, эрх мэдэл, хариуцлага болон тайлагнах тогтолцоонд хяналт тавих;

3.9.2.5 Хөндлөнгийн болон дотоод аудитын тайлан, аудитуудын ажлын гүйцэтгэл, тайланг хугацаанд нь үнэн зөв ирүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

3.9.2.6 Хөндлөнгийн болон дотоод аудитын тайлантай холбоотой асуудлыг ТУЗ-д танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулах;

3.9.2.7 Дотоод аудитуудыг сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.9.2.8 Бусад холбогдох асуудал.

3.10.3 Урамшууллын асуудал эрхэлсэн хороо:

- 3.9.3.1 Банканд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.9.3.2 ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлох;
- 3.9.3.3 Гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих;
- 3.9.3.4 ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- 3.9.3.5 Бусад холбогдох асуудал.

3.9.4 Хүний нөөцийн асуудал эрхэлсэн хороо:

- 3.9.4.1 ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, ажлын гүйцэтгэлийн тайланг хувьцаа эзэмшигчдэд жил бүр тайлагнах;
- 3.9.4.2 ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдлын талаар ТУЗ-д тайлагнах;
- 3.9.4.3 ТУЗ-ийн гишүүнийг томилох, үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;
- 3.9.4.4 ТУЗ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, хэрэв хангаагүй тохиолдолд нэр дэвшигч болон ТУЗ-ийн гишүүнд бичгээр мэдэгдэх;
- 3.9.4.5 ТУЗ-ийн гишүүн нас барах, хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хугацаанд орлон гүйцэтгэгчийг томилон ажилуулах;
- 3.9.4.6 Гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх этгээдийг ТУЗ-д танилцуулах;
- 3.9.4.7 Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл болон гэрээний биелэлтийг дүгнэж, ТУЗ-д танилцуулах;
- 3.9.4.8 Бусад холбогдох асуудал.

- 3.10 ТУЗ нь Компанийн тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх удирдлагаас хараат бус ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл ажлын албатай байна.

ДӨРӨВ. Банкны толгой компани, тэдгээрийн хараат болон охин компани

- 4.1 Толгой компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь банкны нэгдлийн хэмжээнд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий стратеги, бодлого боловсруулж, салбар компаниудад зориулсан зохистой засаглалын оновчтой бүтцийг нэвтрүүлэх, толгой болон салбар (охин) компаниудад зориулсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

- 4.2 Компани болон банкны нэгдэлд хамаарагдах охин, хараат компаниудын хооронд хийгдсэн гэрээ хэлцэл нь ТУЗ-өөс баталсан бодлогын дагуу хараат бус байдлаар хийгдсэн байна. Энэхүү гэрээг Банкны тухай хуулийн 17.3 дахь заалт, Компанийн тухай хуулийн 91,92 дугаар заалтуудад нийцүүлнэ.

ТАВ. Гүйцэтгэх удирдлага

- 5.1 Банкны гүйцэтгэх удирдлага гэдэгт гүйцэтгэх захирал, дэд захирал болон банкны нэгжийн захирлыг хамруулан ойлгоно.
- 5.2 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээ эрх хэмжээний хүрээнд банкныг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй байна.
- 5.3 Гүйцэтгэх удирдлага нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай болон Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 5.3.1 Банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, жилийн төсөв, бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагаанд мөрдөж ажиллах бодлого, дүрэм, журам, зааврыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах;
- 5.3.2 ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө, бодлого, дүрэм, журам, заавар, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, мөрдүүлэх;
- 5.3.3 Банкны ажилтныг албан үүргээ сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл гүйцэтгэх удирдлагад бичгээр мэдэгдэх тогтолцоог бүрдүүлэх;
- 5.3.4 Банкны эрсдэлд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачлага гарган ажиллах, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон хязгаарлалт, Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт алдагдсан тохиолдолд зохих арга, хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 5.3.5 Банкны үйл ажиллагааны онцлог болон учирч болзошгүй эрсдэлийн түвшинтэй уялдуулан удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаа болон түүний аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 5.3.6 Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.3.7 Банкны хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийг зөрчих, банкны үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулах магадлалтай бол банкны гүйцэтгэх удирдлага нь уг үүргийг биелүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар Монголбанкинд мэдэгдэх;
- 5.3.8 Харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны бусад холбогдох этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдол бүрт ТУЗ-д мэдэгдэх.

ЗУРГАА. Эрсдэлийн удирдлага

- 6.1 ТУЗ, Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгжийг бие даасан хэлбэрээр зохион байгуулж, банкинд учирч болох эрсдэлийг удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэх ба эрсдэлийн удирдлагын нэгжийн ажилтны эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагын тогтолцоо болон тайлагнах зарчмыг нарийвчлан тогтооно.
- 6.2 Эрсдэлийн удирдлагын нэгж нь банканд учирч болох эрсдэлийг нээн илрүүлэхэд шаардагдах банкны дотоод мэдээллийн системд нэвтрэх эрх, хүн хүч, хөрөнгө нөөц, үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллээр хангагдсан байна.
- 6.3 Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилт болон эрсдэлийн ерөнхий түвшингийн талаар ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороонд тодорхой хугацаанд давтамжтайгаар тайлагнана.
- 6.4 Эрсдэлийн удирдлагын нэгжийн удирдах албан тушаалтан тухайн эрсдэлийн банканд учруулах үр дагаврыг үнэлэх, дүгнэх чадвартай байна.
- 6.5 Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг дараах үе шаттай хэрэгжүүлнэ:
- 6.5.1 Банканд учирч болох эрсдэлийн төрлийг тодорхойлох;
 - 6.5.2 Төрөл тус бүрт харгалзах эрсдэлийн түвшинг тодорхойлох;
 - 6.5.3 Шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох;
 - 6.5.4 Эрсдэл хүлээх шийдвэр нь ТУЗ-өөс баталсан бодлого болон бусад бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэхийг хянах;
 - 6.5.5 Эрсдэлийн үр дагаврыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнах.
- 6.6 Эрсдэлийн удирдлагын нэгж нь учирч болох эрсдэлийг банкны нэгдэл, салбар нэгж, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ.
- 6.7 Томоохон харилцагчийн үйл ажиллагааны онцлог, салбар нэгж болон бизнесийн чиглэл бүрээр эрсдэлийг үнэлнэ.
- 6.8 Банкны зээлийн хөрвөх чадвар, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад бизнесийн үйл ажиллаганы эрсдэлийг тодорхойлж улмаар нэгж тус бүрт учирч болох эрсдэлийг шинжилж, дүгнэлт гаргаж, шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавина.
- 6.9 Банкны үйл ажиллагааны чиглэл тус бүрээр газар, хэлтсийн хооронд мэдээлэл солилцох, мэдээллийн хэвтээ бүтэц, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангах, мэдээллийн босоо бүтцийг бүрдүүлсэн байна.

ДОЛОО. Хөндлөнгийн болон дотоод аудит

- 7.1. Дотоод аудитын нэгж нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 7.1.1 Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулах;

- 7.1.2 Дотоод аудитын тайлангаар өмнө гарсан зөрчил, дутагдлыг хэрхэн биелүүлж байгаад эргэн хяналт тавьж ажиллах;
 - 7.1.3 ТУЗ-өөс баталсан бодлого, дүрэм, журам, зөвлөмжийг банкны гүйцэтгэх удирдлага биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 7.1.4 Банкны зохистой засаглал, санхүү тайлагнал, дотоод хяналт, мэдээллийн систем болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.1.5 Гүйцэтгэх удирдлагаас хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д хүргүүлж буй тайлан мэдээ нь үнэн зөв эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 7.1.6 ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар санаачлагатай ажиллах;
 - 7.1.7 Банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, гүйцэтгэх удирдлагаас эрсдэлийг бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь гэрээ хэлцэл, хүлээж болзошгүй алдагдлын хэмжээтэй уялдаж байгаа талаар үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.1.8 Банкны эрхлэх үйл ажиллагаа, тэдгээрт харгалзах эрсдэл, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар аудитын дүгнэлтэд тусгаж, хяналт шалгалт нь банканд учирч болох эрсдэлийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн байх;
 - 7.1.9 Банкны үйл ажиллагааны нэгж тус бүрт үүсэх эрсдэлийг илрүүлэх, хүлээж болзошгүй алдагдлын хэмжээ болон шаардагдах хөрөнгийн талаар судалгаа, шинжилгээ хийж удирдлагад танилцуулж, тайлагнасан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.1.10 Банкнаас зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах тохиолдолд учирч болох эрсдэлийн талаар дүн шинжилгээнд үнэлгээ дүгнэлт өгөх;
 - 7.1.11 Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон эрх бүхий байгууллагаас гүйцэтгэх удирдлагад тавьсан шаардлагыг биелүүлсэн эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.1.12 Банкны үйл ажиллагаанд үнэлэлт өгч, шалгалтын акт материал, хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг боловсруулан ТУЗ-ийн дэргэдэх хороодод тухай бүр танилцуулах;
 - 7.1.13 Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн талаар үнэлгээ, дүгнэлт гаргах.
- 7.2 Хөндлөнгийн аудит нь банкны зохистой засаглалыг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох үүднээс дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 7.2.1 Банкинд хөндлөнгийн аудит хийх явцад банкны үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн эрсдэлээр зохих хэмжээний үнэлэлт, дүгнэлт өгсөн байх;
 - 7.2.2 Банкнаас аудитын хүрээнд гаргаж өгсөн аливаа төрлийн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв эсэхийг магадлан шалгаж, баталгаажуулах;
 - 7.2.3 Банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлсэн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

- 7.2.4 Банкны зүгээс Хууль эрх зүй, ТУЗ-өөс баталсан бодлого, дүрэм, журам, зөвлөмжийг хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх;
- 7.2.5 Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн талаар үнэлгээ, дүгнэлт гаргах;
- 7.2.6 Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг удирдлагын захидлын хамт Монголбанкинд ирүүлнэ.

НАЙМ. Ил тод байдлыг хангах

- 8.1 Банканд зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангахад Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна дараах мэдээллийг банкны цахим хуудсаар тайлагнана:
 - 8.1.1 Банкны эрхэм зорилго, хэтийн зорилт;
 - 8.1.2 Банкны хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, бүтцийг эцсийн өмчлөгчөөр;
 - 8.1.3 Банкны толгой компани, банкны нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн үйл ажиллагааны талаар;
 - 8.1.4 Банкны тухай хуулийн 38.2.4 дэх хэсэгт заасан этгээдийн нэрс, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлагын талаар;
 - 8.1.5 Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, түүнтэй адилтган үзэх актив хөрөнгийн талаарх мэдээллийг зээлдэгч, олгосон зээл, өөрийн хөрөнгөд эзлэх хувь зэргээр дэлгэрэнгүй байдлаар;
 - 8.1.6 Банкны толгой компани, тэдгээрийн зэргэлдээ компанийн засаглалын зарчмын талаар;
 - 8.1.7 Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;
 - 8.1.8 ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар баталгаажуулсан жилийн тайланд банкны нийгмийн хариуцлагын талаар.

ЕС. Хяналт, хариуцлага

- 9.1. Банк нь энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу банкныхаа зохистой засаглалын үнэлгээг жил тутам хийж, баталгаажуулсан тайланг албан бичгээр болон цахим хэлбэрээр жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дараах баримтыг хавсарган Монголбанкинд ирүүлнэ:
 - 9.1.1. Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний тайлант жилийн ажлын тайлан;
 - 9.1.2 Компанийн тухай хуулийн дагуу тайлант жилд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт;
 - 9.1.3 Тайлант жилийн дараах хурлаар хэлэлцсэн асуултын жагсаалтыг доорх хүснэгтийн дагуу гаргаж ирүүлнэ:
 - 9.1.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал;
 - 9.1.3.2 ТУЗ-ийн хурал;

9.1.3.3 ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны хурал;

9.1.3.4 ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны хурал;

9.1.3.5 ТУЗ-ийн дэргэдэх хүний нөөц, урамшууллын хорооны хурал.

№	Хэлэлцсэн асуулт	Дэмжсэн гишүүний тоо	Татгалзсан гишүүний тоо	Санал	Ирц	Шийдвэрлэсэн нь
1	...	...	...	...	...	...

9.1.4 Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг удирдлагын захидлын хамт;

9.1.5 Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох баримт бичиг.

9.2 “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын нэгдүгээр хавсралтын дагуу банкаас ирүүлсэн тайланг Монголбанкны Хяналт шалгалтын газар дахин үнэлж, үнэлгээний хариуг жил бүрийн 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор банкинд хүргүүлнэ.

9.3 Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, журмын заалтыг зөрчсөн этгээдэд Банкны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____

“Банкны зохистой засаглалын зарчмыг
хэрэгжүүлэх журам”-ын нэгдүгээр хавсралт

**Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг
үнэлэх үнэлгээний загвар**

“Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ыг “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын хамт ашиглана. Энэхүү загвар нь 100 асуулт буюу дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

№	Гарчиг	Байвал зохих оноо	Банкны үнэлгээ	Хянан шалгагчийн үнэлгээ	Зөрүү
1	Ил тод байдал	8.0	8.0	8.0	-
2	Хувьцаа эзэмшигчдийн зохистой засаглал	14.0	14.0	14.0	-
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг	33.0	33.0	33.0	-
4	Гүйцэтгэх удирдлага	16.0	16.0	16.0	-
5	Эрсдэлийн удирдлага ба дотоод хяналт	13.0	13.0	13.0	-
6	Дотоод аудит	10.0	10.0	10.0	-
7	Хөндлөнгийн аудит	6.0	6.0	6.0	-

	Нийт дүн	100.0	100.0	100.0	-
--	-----------------	--------------	--------------	--------------	---

Тайланг “Банкуудын зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ын дагуу дараах байдлаар үнэлнэ:

1. Биелэлтийг үнэлэхдээ асуулт тус бүрийн хувьд бүрэн биелсэн бол 2, хагас биелсэн бол 1, биелээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлж, тухайн асуултын хувийн жинг харгалзах оноогоор үржүүлэн, үржвэрийн дунджаар тооцож, холбогдох тайлбарыг ирүүлнэ;
2. Нэгдсэн үнэлгээний дүнгээс хамаарч банкны зохистой засаглалын журмын хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:
 - 2.1 Нэгдсэн үнэлгээ 80 оноогоос дээш байвал сайн засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаа хэвийн;
 - 2.2 Нэгдсэн үнэлгээ 65-79 оноо байвал дунд засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;
 - 2.3 Нэгдсэн үнэлгээ 50-64 оноо байвал хангалтгүй засаглалтай буюу банкинд хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;
 - 2.4 Нэгдсэн үнэлгээ 49 оноогоос доош байвал муу засаглалтай банк буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай.

БАНКНЫ НЭР:										
I. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛ										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагчийн үнэлгээ		Тайлбар /нийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигтэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигтэсэн үнэлгээ	
1	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	1.00	Толгой компанийн ТУЗ болон гүйцртгэх удирдлага нь нийт групп компанийн хэмжээнд зохистой засаглалыг хангах зорилгоор ерөнхий стратеги, бодлого боловсруулж, салбар компаниудад зориулсан зохистой засаглалын оновчтой бүтцийг нэвтрүүлэх, толгой болон нийт салбар компаниудад зориулсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх үүрэгтэй.	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Толгой компанийн ТУЗ-ийн зүгээс нийт групп компанийн хэмжээнд зохистой засаглалыг хангах зорилгоор ерөнхий стратеги, бодлогыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Бодлогын баримт бичгүүдийн батлагдсан огноо, дугаар, хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьдаг талаар тайлбарлах, компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог тайлбарлах, Үүнд: бүтэц, томилсон эрх бүхий этгээд, түүний ажил үүрэг
2		1.00			Банк болон зэргэлдээ компаниудын хоорондын гэрээ хэлцэл нь ТУЗ-өөс боловсруулсан бодлогын дагуу хараат бус байдлаар хийгддэг эсэх					Гэрээ хэлцэл нь бодлогын баримт бичигт заасны дагуу хараат бусаар хийсэн байдал, Бодлого, журмын хэрэгжилтийн талаар тайлбарлах, ТУЗ-өөс баталсан гэрээ, хэлцэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбарлах,
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, түүнийг хэрэгжилт	1.00	Банкны засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд хяналт тавих, бүртгэлд хамрагдах, хурлын шийдвэр гаргалтад оролцох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох зэрэг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах ёстой. Хувьцаа эзэмшигчид аливаа саад хүндрэлгүйгээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, саналаа өгөхийн зэрэгцээ хувьцааны эзэмшлийн талаарх бүх мэдээлэл, хуралд оролцогсдын нэрсийн жагсаалт, материаллаг болон материаллаг бус санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг олж авах эрхтэй.	Компанийн тухай хуулийн 60-74 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийн талаар холбогдох дүрэм, журамд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Холбогдох дүрэм, журмын заалт, хяналт тавих тогтолцоо бүрдүүлсэн байдал, Үүнд: томилсон эрх бүхий этгээд, түүний ажил үүрэг, түүнд тавих хяналт, тайлагналын тогтолцоо,
4	Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа шилжүүлэх, худалдан авах эрх	1.00	Хувьцаа эзэмшигчид хүссэн үедээ өөрийн хувьцаагаа бусдад шилжүүлэх эрхтэй. Хувьцааны урьдчилсан эрх нь тодорхой этгээдэд зориулж хаалттай хүрээнд хувьцааг нэмж гаргах тохиолдолд хувьцааны эзэмшлийн хувиа хадгалан үлдэх боломжийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд урьдчилан олгох эрхтэй.	Компанийн тухай хуулийн 38,50,54, 56 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцаагаа хуулийн дагуу бусдад чөлөөтэй худалдан борлуулах, шилжүүлэх, мөн банк шингээр хөрөнгө оруулалт татах зорилгоор хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргах тохиолдолд одоогийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдаж авах эрх буюу хувьцааны урьдчилсан эрхийг нь эдлүүлэх бодлого, журмыг мөрддөг эсэх					Журмын заалт, тохиолдол бүрийг дурдах. Үүнд: журмын хэрэгжилт болон тайлагнах тогтолцоог тайлбарлах,
5	Хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах	1.00	Компанийн засаглалын тогтолцоо нь жижиг хувьцаа эзэмшигчид, гадаадын хувьцаа эзэмшигчид зэрэг нийт хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах явдлыг баталгаажуулна. Эрх нь зөрчигдсөн нийт хувьцаа эзэмшигчид эрхээ үр дүнтэй сэргээлгэж, хохирлоо бүрэн барагдуулах боломжоор хангагдах ёстой.	Компанийн тухай хуулийн 60-74 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Жижиг болон гадаадын хувьцаа эзэмшигчид санал гаргах, хэлэлцж буй асуудлын талаар лавлагаа авах эрхээр хангагдсан эсэх					Энэ талаар журамд тусгасан эсэх, гомдол, санал гарсан, хэрхэн шийдвэрлэсэн эсэх
14										

ТӨСӨЛ

6	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл	1.00	Компанийн засаглалын хүрээнд жижиг болон гадаад хувьцаа эзэмшигч гэх мэт бүх хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах байдлыг хангах. Бүртгэлийн систем нь хувьцаа эзэмшигчийн өмчлөлийн статусын талаарх бүрэн мэдээллийг агуулсан байх.	Компанийн тухай хуулийн 45.1-45.8 дугаар зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банк нь банкны үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг тогтмол хөтөлдөг эсэх					Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн талаарх мэдээллийг хавсаргах. Хувьцаа эзэмшигчийн мэдээллийг эцсийн өмчлөгч хүртэл задалж мэдээлэх. Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн өмчлөгчийг мэдээлэх шаардлагатай. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон гаргасан хувьцааны тоо, төрлийг банкны дүрэмд тусгасан эсэх
8	Хувьцаа эзэмшигчдийн оролцоо	1.00	Банк нь компанийн засаглалын томоохон шийдвэр гаргалт, тухайлбал ТУЗ-ийн гишүүдийг томилох, стратеги боловсруулахад хувь нийлүүлэгчдийн үр дүнтэй оролцоог хангасан байх. Хувь нийлүүлэгчид ТУЗ-ийн гишүүдийг чөлөөтэй сонгох эрхтэй. Хувьцаа эзэмшигчид банкны бүхий л хуралд оролцож, хувьцааны эзэмшлийнхээ дагуу саналаа өгөх эрхтэй.	Компанийн тухай хуулийн 62.1.7, 77 дугаар зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, стратеги боловсруулах зэрэг засаглалын гол шийдвэрүүдийг гаргахдаа хувьцаа эзэмшигчдийн идэвхтэй оролцоог хангаж, кумулятив аргачлал ашиглан санал хураасан эсэх					Энэ талаар банкны дүрэмд тусгасан эсэх, Банкны ТУЗ-ын гишүүд, ТУЗ-ийн хараат бус гишүүд, Гүйцэтгэх захирлыг томилсон хурлын ирц, оролцогчид, саналын хувь. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болсон эсэх, хэрэв тийм бол хурлын тэмдэглэл, шийдвэрийн огноо, дугаар, Хувьцаа эзэмшигчдийн зүгээс баталсан стратегийн баримт бичгийн огноо, дугаар,
9	Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрх, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт, зар хүргүүлэх	1.00	Хувьцаа эзэмшигчид банктай холбоотой мэдээллийг тогтмол, цаг тухайд нь авах бүрэн эрхтэй. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, бэлтгэх, хүрэлцэн очих боломжийг хангахын тулд хурлын зарыг бичгээр урьдчилан хүргүүлэхдээ хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хавсаргах. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлан хуралдуулах ёстой.	Компанийн тухай хуулийн 59.4, 60.4, 59-61, 64.2, 65, 66, 98 дугаар зүйл. Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлын материалыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэн хүргүүлэх, мөн ТУЗ нь банкны үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж ажилласан эсэх					Хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэдээллээр хангах, хурлын зохион байгуулалт, зар хүргүүлсэн байдал
10	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл	1.00	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан өдрөөс хойш зохих хугацааны дотор хурлын тэмдэглэлийг эцэслэн баталгаажуулах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогсдын нэрс, хурлаар хэлэлцсэн асуудал, санал хураалтын явц, санал хураалтад оролцогсдын тоо, санал хураалтын дүн, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өгсөн саналын тоо зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл багтсан байх ёстой.	Банкны тухай хуулийн 31.6, Компанийн тухай хуулийн 74.1 зүйл	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг баталгаажуулан холбогдох шийдвэрийн хамт Монголбанкнд ажлын 45 хоног дотор хүргүүлсэн эсэх					Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хуралдсан хурлын тэмдэглэл болон холбогдох шийдвэрийг Монголбанкнд хүргүүлсэн байдал.

ТӨСӨЛ

11	Ногдол ашгийн хуваа	1.00	Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн ашиг болон ногдол ашиг хүртэх эрхтэй. Мөн ногдол ашгийн хэмжээ, түүнийг хуваарилах өдрийн талаар мэдээлэлтэй байж цаг тухайд нь авах эрхтэй.	Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл	Банкны ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах аргачлалыг холбогдох дүрэм, журамд тусгаж, ногдол ашгийн төлбөр авсан эсэх, энэ төлбөрийг шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн болон бусад төрлийн мэдээллийг хувь нийлүүлэгчдэд танилцуулсан эсэх,					Банкны дүрэм, хувь нийлүүлэгчдийн гэрээний заалт, холбогдох шийдвэр, баримт бичгийн жагсаалт, төлбөр шилжүүлсэн огноо
12	Ашиг сонирхлын зөрчил	1.00	Хувьцаа эзэмшигчид буюу оролцогч талуудын өмчлөлийн эрх, банкны үнэ цэнэд нөлөөлөх аливаа хэлцэлд материаллаг ашиг сонирхолтой эсэх талаар тайлагнаж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх	Компанийн тухай хуулийн 87,88 дугаар зүйл	Банк болон хувьцаа эзэмшигчдийн хооронд сонирхлын зөрчил үүсч болох арилжаа гүйлгээ /их хэмжээний хэлцэл г.м/-г хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан эсэх					Тохиолдол бүрийг танилцуулах, Үүнд: сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэл, холбогдон гаргасан шийдвэрийг тайлагнах.
13	Холбогдох этгээдтэй хийх хэлцэл	1.00	ТУЗ нь банкны дүрэм, журамд заасны дагуу оролцогч талуудтай хийсэн материаллаг, санхүүгийн болон бизнесийн бүх хэлцэл, мөн холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл бүрийн дэлгэрэнгүй танилцуулгыг жилийн эцсийн тайланд тусгадаг байх, Банкны хувьцаа эзэмшигчдэд хамаарах хэлцлийг ТУЗ-д тайлагнахыг шаардаж, ТУЗ-ийн гишүүд хоорондын харилцааг зөв зохистой байлгаж, хяналт тавих ёстой.	Компанийн тухай хуулийн 87-89, 96.1.3 болон 99 дугаар зүйл	Банкны холбогдох этгээдэд зээл олгох болон бусад холбогдох этгээдтэй хийх гэрээ, хэлцэл нь журмын дагуу явагддаг эсэх					Үүнд:Холбогдох журмын заалт, Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д танилцуулсан хурлын тэмдэглэлийн дугаар, огноо, Банкны холбогдох этгээдэд тавигдах хязгаарлалтуудыг зорчсон тохиолдол бүрийг мэдэгдэх, энэ талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргах, хийсэн гэрээ хэлцэлийг санхүүгийн тайланд тодруулага хэлбэрээр оруулж тайлагнасан эсэх
14	Банкны хувьцааны хяналтын багцын зах зээл	1.00	Банкууд зарим тохиолдолд тодорхой банкны хяналтын багцыг бүрдүүлэхээр худалдан авах эсхүл өөрийн хөрөнгийн нэлээд хэсгийг худалдах гэх мэт онцгой хэлцэл хийдэг. Энэ тохиолдолд нийт хувьцаа эзэмшигчдийн хувьцааны эзэмшлийн төрөл, ангилалд хамаарах эрхийг хамгаалахын тулд эдгээр бүх хэлцлийн үнийг нл тод байлгаж, шударга нөхцлөөр хийх ёстой	Компанийн тухай хуулийн 53-56 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйл	Хөрөнгийн зах зээлд банкны хяналтын багцыг худалдан авах, мөн банк нэгдэх, банкны хөрөнгийн томоохон хэсгийг худалдах, худалдан авах талаар журам боловсруулж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагад тайлагнасан эсэх					Тохиолдол бүрийг эрх бүхий байгууллагад тайлагнасан байдал, Үүнд: Хүргүүлсэн албан тоотын огноо, дугаар
15	ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ	1.00	ТУЗ нь тус зөвлөлийн нийт гишүүдийн ажлын нэгдсэн гүйцэтгэл болон гишүүн тус бүрийн гүйцэтгэлийг өмнө тогтоосон бэнчмарктай харьцуулан жил бүр үнэлдэг байх	Компанийн тухай хуулийн 81.5.4 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн эсэх,					Холбогдох журам, үнэлгээний аргачлал, давтамж, үнэлэх тогтолцооны талаар тайлбарлах
НИЙТ ДҮН		14.00					14.0		14.0	

II ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагчийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	
1	Компанийн эрхэмлэх үнэ цэнэ болон ёс зүйн дүрэм	1.0	ТУЗ нь банкны нийт ажиллагсад, оролцогч талуудтай хамтран ёс зүйн цогц дүрмийг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь тэдний мэргэжлийн хийгээд ёс зүйн харилцааг зохицуулахын хамт ёс зүйгүй, хууль бус үйлдлийн талаар мэдээлэх, түүний нууцлалыг хадгалах журмыг боловсруулсан байна.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ нь банкны нийтээр мөрдөн ажилладаг банкны үнэт зүйлс, ёс зүйн дүрмийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх	2	1.0	2	1.0	Үүнд:ТУЗ нь өөрийн болон гүйцэтгэх дээд удирдлага, бусад ажилтнуудын шударга байдлыг дэмжсэн мэргэжлийн стандарт, байгууллагын үнэт зүйлс, ёс зүйн дүрэм зөвшөөрөгдөх болон үл зөвшөөрөгдөх зан үйлийг тодорхойлсон байдал
2	Компанийн засаглалын бодлого	1.0	ТУЗ нь байгууллагын бизнесийн зорилго зорилт, стратеги, үүрэг хариуцлага, үнэт зүйлс, эрсдэлийн стратеги, хүлээх эрсдэлийг тусгаж баталсан маш тодорхой удирдамж бүхий баримт бичигтэй байна. ТУЗ байгууллагын үнэт зүйлс зэргийг тодорхойлоход манлайлан оролцох ёстой. Компанийн засаглалын бодлогын баримт бичиг нь дээрх болон бусад асуудлын талаар ойлгомжтой, тодорхой удирдамж чиглэлээр хангадаг байх ёстой.	Банкны тухай хуулийн 31.3.7 дахь заалт, Монгол улсын Компанийн засаглалын кодекс, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны зохистой засаглалын бодлого, журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх	2	1.0	2	1.0	Үүнд: Банкны зохистой засаглалын бодлого, Банкны дүрэм, ТУЗ-ийн ажиллах журам, банкны дотоод журмуудыг баталсан огноо, дугаар. Банкны засаглалын бодлогод шударга ёс, үүрэг хариуцлага, ил тод байдал, хариуцан тайлагнах зарчмыг хэрхэн тусгасан талаар тайлбарлах
3	ТУЗ-ийн гишүүд, үйл ажиллагааны хараат бус байдал	1.0	Санхүүгийн байгууллагын ТУЗ нь бизнесийн үйл ажиллагаагаа зохистой, үр ашигтай явуулахын тулд гүйцэтгэх удирдлагыг удирдлага, удирдамж чиглэлээр хангаж, хяналт тавихад шаардагдах мэргэжлийн, дадлага туршлагатай хангалттай тооны гишүүдтэй байх хэрэгтэй. ТУЗ-ийн бүрэлдэхүүний тоог: 1. үр бүтээлтэй, бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэх; 2. шуурхай, оновчтой шийдвэр гаргах; 3. хороод байгуулагдсан тохиолдолд тэдгээрийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах түвшинд тогтоох нь зүйтэй гэж олон улсын шилдэг туршлага зөвлөмж болгодог.	Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, 33 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 77.1, 79 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн гишүүдийн тоо зохимжтой,ТУЗ-ийн гишүүдийн нэгээс доошгүй гишүүн нь туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч эсвэл санхүүчээс бүрдсэн эсэх	2	1.0	2	1.0	Үүнд: ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс, тоо, ТУЗ-ийн гишүүд болон хараат бус гишүүнд тавигдах шалгуурын дагуу Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийн авсан эсэх, ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээ, түүнд тусгасан үүрэг, хариуцлагыг тодорхой заасан байдал, мэргэшсэн байдал.
4		1.0	ТУЗ-ийн гишүүд итгэл үнэмшилтэй байж, үнэнч шударга, няхуур ажиллаж, асуудалд анхааралтай, нухацтай хандаж, байгууллага болон харилцагчдын эрх ашгийг өөрийн хувийн эрх ашгаас дээгүүр тавьж, шийдвэр гаргахдаа байгууллага болон үйлчлүүлэгчдийн эрх ашгийг харгалзан хараат бус дүгнэлт гаргах, асуудалд бодитой хандаж, өөрийн албан тушаалаа буруугаар ашиглах замаар хувьдаа давуу байдал олох эсхүл байгууллагад аливаа хохирол учруулах үйлдэл гаргахгүй ажиллах.	Банкны тухай хуулийн 31.4 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын зөвлөмжийн 3.2 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн дарга, гишүүд нь банкны удирдлага, улс төрийн, том хувь нийлүүлэгчдийн нөлөөлөл болон бусад гадны зохисгүй нөлөөнөөс үл хамааран зөвхөн банкны эрх ашгит нийцсэн шийдвэр гаргаж байгаа эсэх	2	1.0	2	1.0	Үүнд:ТУЗ-ийн үйл ажиллагааны журам баталсан дугаар, огноо. Журамд Банкны тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үүргийг тусгаж өгсөн заалт, үүргийн хэрэгжилтийг хэрхэн хянадаг талаар тайлбарлах, Монголбанкнд тайлагнасан байдал
5	ТУЗ-ийн гишүүдийн чадвар, туршлага	1.0	ТУЗ-ийн гишүүд өөрсдийн албан тушаалд тохирохуйц мэргэжил, боловсролтой байхын хамт сургалтанд хамрагдах зэргээр мэргэжил боловсролоо байнга дээшлүүлэх ёстой. Тэд компанийн засаглал дахь өөрсдийн үүрэг ролийг сайтар ойлгодог, банкны үйл ажиллагааны талаар оновчтой, голч дүгнэлт гаргаж чаддаг байх шаардлагатай.	Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 8 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын зөвлөмжийн 3.3.9 дэх заалт	ТУЗ-ийн гишүүдийн зохистой засаглалын талаар мэргэшсэн байдлыг хангасан эсэх	2	1.0	2	1.0	Үүнд: Сургалт зохион байгуулсан газар, хамрагдсан хугацаа, сертификатын дугаар, мэргэшлийн нэр, гэрчилгээний дугаар, огноо, жилд нэгээс доошгүй удаа зохистой засаглалын сургалтад хамрагдсан эсэх

6	ТУЗ-ийн гишүүдийн хурлыг зарлах, хуралдуулах,	1.0	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь саналын хуудсыг хүргүүлэх, бөглөгдсөн болон бөглөгдөөгүй саналын хуудсын цуглуулах, ТУЗ-ийн хурлын ажиглагаа, дэгийг дагаж мөрдөх асуудлыг зохицуулах; хурлын тэмдэглэл хөтлөх, аман тайлан, танилцуулгыг тэмдэглэх зэрэг ажлыг хариуцна. ТУЗ гишүүдийнхээ үүрэг хариуцлага, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, журмыг батлан хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь тэдний чиг үүргээ гүйцэтгэхэд шаардагдах банкны талаарх бүх мэдээ мэдээллийг олж авах эрх мэдлийг баталгаажуулдаг байх	Компанийн тухай хуулийн 79-82 дугаар зүйл	ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилж, ТУЗ-ийн хурлыг журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх	2	1.0	2	1.0	Журмын огноо, дугаар, томилсон огноо, дугаар. Нбд-ын ажл үүргийн биелэлтийн талаар ТУЗ-ийн гишүүн бүрээс санал авч хавсаргах
7	Хурлын ирцийн бүртгэл,ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийн чанар	1.0	Гишүүдийн ирцийг ил тод тайлагнаж, мэдээлж байх ажиллагааг ТУЗ-өөс үр дүнтэй зохицуулж, хатуу хяналт тавих ёстой. ТУЗ-ийн нийт гишүүд жилийн туршид ТУЗ-ийн хуралд ирц сайтай оролцсон байх хэрэгтэй.	Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 1,11, 12, 13,14 дүгээр заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 6 дугаар заалт	ТУЗ-ийн хурлыг банкны дүрэмд заасан тооноос доошгүй удаа хуралдуулж, ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг баталгаажуулан, хэлэлцсэн асуудалтай холбоотой баримт материал, гаргасан шийдвэрийн хамт тогтоосон хугацаанд Монголбанкнд хүргүүлсэн байх	2	1.0	2	1.0	Үүнд:ТУЗ-ийн хурлаар жилийн турш хэлэлцсэн асуудлууд, хуралдсан огноо, гишүүдийн ирц, шийдвэрлэсэн асуудал, Монголбанкнд хүргүүлсэн огноогоор жагсаан хавсаргах
8	Бизнес төлөвлөгөө, бодлого боловсруулалт	1.0	ТУЗ болон гүйцэтгэх дээд удирдлага нь банкны алсын хараа, эрхэм зорилгын мэдэгдэл, гүйцэтгэлийн үнэлгээний систем зэргийг тусгаж, сайтар томъёолсон стратегийн удирдлагын баримт бичгийг боловсруулах хэрэгтэй. Банкны стратеги нь шалтгаан-үр дагаврын цуврал уялдаа холбоогоор дамжин хэрэгждэг.	Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.1 дэх заалт,Банкны зохиистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны стратеги, бизнес төлөвлөгөө, жилийн төсөв, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлогыг баталж, биелэлтийг хянах эрх бүхий албан тушаалтныг томилж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх	2	1.0	2	1.0	Үүнд: Баталсан огноо, дугаар, томилсон тушаал, биелэлт хянах эрх бүхий тушаалтны ажил үүргийн хуваарь, биелэлтэд тавих хяналт тогтолцоо болон түүний тайлагналын талаар тайлбарлах
9	Сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, зохицуулах	1.0	Банк компанид зээл олгох, түүний эзэмшигч компанийн гаргасан үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжаа хийх, эсхүл банк, түүний харилцагчид болон банкны ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага хоорондын ашиг сонирхол, банк, түүний ТУЗ-ийн гишүүд санхүүгийн ашиг сонирхлын үүднээс аливаа этгээдтэй бизнесийн харилцаанд орох зэргээр банкны төрөл бүрийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотойгоор гарч болзошгүй сонирхлын зөрчлийг олж илрүүлэх, зохицуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг байх	Компанийн тухай хуулийн 92 дугаар заалт, Банкны зохиистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн сонирхлын зөрчлийг шийдвэрлэх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд: Журмын огноо, дугаар, гарч болзошгүй сонирхлын зөрчилд хэрхэн хяналт тавих, тайлагнах, шийдвэрлэх болон тогтолцоог тайлбарлах,
10	Банкны ажилтаны зүй бус үйлийг мэдээлэх	1.0	Банкны хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал болон ажилтан хувийн ашиг сонирхлыг хөндсөн тохиолдолд асуудлыг хэлцэхэд оролцохгүй байх талаар бичгээр мэдэгддэг байх. Зөрчил гарсан тохиолдолд холбогдох мэдээллийн санд бүртгүүлдэг байх	Банкны салбарын ажилтаны ёс зүйн нэгдсэн мэдээллийн сангийн журам-ын 2.3.1 дах заалт	Сонирхлын зөрчил үүсч болох эсхүл үүссэн тохиолдолд тухай бүрт мэдээллийн санд бүртгүүлсэн эсэх					Үүнд:Журмын заалт, Банкны салбарын ажилтаны ёс зүйн нэгдсэн мэдээллийн сангийн журмын дагуу гэрээ байгуулсан эсэх, холбогдох мэдээллийг санд бүртгүүлсэн огноо.

15	Дотоод хяналт	1.0	Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагналын тогтолцоо, дотоод аудит болон хөндлөнгийн аудитын талаар баримтлах бодлого, эрсдэлийн удирдлагын бодлого, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтын талаарх бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааны стандартыг хэрэгжилтийг хангасан бодлого боловсруулсан байх	Банкны тухай хуулийн 31.3.8, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ нь дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичгийг баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					ТУЗ-өөс баталсан бодлогын жагсаалт, түүний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих тогтолцооны талаар тайлбарлах, жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн эсэх, дүгнэлтийг хавсаргах
16		1.0	ТУЗ нь дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаад ДАГ-аас хяналт таьдаг байх	Банкны тухай хуулийн 31.3.8, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн үр, ашигтай явагдаж байгаа талаар ДАГ-аас хяналт тавьж, үр дүнг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг эсэх					Үүнд:тайлагнах журмын заалт, тайлагнасан огноо
17	Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа	1.0	Банк нь Олон улсын аудитын стандартын дагуу найдвартай, бие даасан хөндлөнгийн аудит хийлгэхэд хөндлөнгийн аудиторт тодорхой шаардлага тавьдаг байх, ТУЗ нь банкны бүх газар, хэлтэс, нэгжийг хөндлөнгийн аудиторуудтай хамтран ажиллах боломжоор хангадаг байх.	Банкны тухай хуулийн 40.1, Компанийн тухай хуулийн 76.1.10, Аудитын тухай хуулийн 11.2, 5.8	ТУЗ болон Аудитын хороо нь банкны санхүүгийн тайланг тодорхой давтамжтайгаар хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үйл ажиллагаанд хяналт тавьж буй эсэх					Үүнд: Хөндлөнгийн аудиторд тавигдах шалгуур, жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг ТУЗ-өөр баталгаажуулж, Монголбанкнд хүргүүлсэн огноо
18		1.0	ТУЗ-өөс хөндлөнгийн аудитаас гаргасан санал зөвлөмжийн дагуу алдаа дутагдлыг хугацаанд нь засаж залруулах арга хэмжээг авч ажилласан байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын зөвлөмжийн 6.1 дэх заалт	Хөндлөнгийн аудитын тайланд тусгагдсан банкны үйл ажиллагааны талаарх санал зөвлөмжийг Аудитын Хороо болон ТУЗ-өөр авч хэлэлцэн хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд:Хөндлөнгийн аудитын тайланд тусгагдсан санал, зөвлөмж, банкны үйл ажиллагааны талаар алдаа дутагдлыг хэрхэн залруулсан талаар
19	Харилцагчдын эрх ашгийг хамгаалах	1.0	ТУЗ нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж, тэдгээрийг сайжруулах арга хэмжээг тогтмол авдаг байх. Харилцагчдын эрх ашгийг хамгаалах бодлогын баримт бичигт харилцагчаа таньж мэдэх, бизнесийн нэр төрөл, банкны бүтээгдэхүүн болон холбогдох мэдээллийг өгөх аргачлал, харилцагчын зүгээс ирүүлсэн санал дүгнэлтийг хүлээн авах, холбогдох арга хэмжээг авах, харилцагчийн хувийн мэдээлэл хадгалах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-өөс Харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах бодлогын баримт бичгийг батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд: Журам батлагдсан огноо, дугаар, бодлогын хэрэгжилтийг хянаж, тайлагнасан байдал, аудитын хороо болон гадаад, дотоод аудиторуудын тайланд үндэслэн харилцагчидын эрх ашгийг хамгаалах талаар банкнаас авч буй арга хэмжээнд өгсөн үнэлэлт , дүгнэлт
20	ТУЗ-ийн дэргэдэх хороод	1.0	ТУЗ эрх, үүргээ хэрэгжүүлэх үүднээс Эрсдэлийн хороо, Аудитын хороо, Цалин урамшуулын хороо, Нэр дэвшүүлэх хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороонд ажиллах гишүүдийн тоо, бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны талаар журамд тодорхой тусгасан байна.	Банкны тухай хууль, Компанийн хууль Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Аудитын хороо, Цалин урамшуулын хороо, Нэр дэвшүүлэх хороод нь журмын дагуу хуралдаж, ТУЗ-д тогтмол тайлагнадаг эсэх					Үүнд:ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам болон хороонд ажиллах гишүүдийг томилсон тогтоолын дугаар огноо,журмын хэрэгжилтийг хэрхэн хянах талаар тайлбарлах

21	Эрсдэлийн удирдлагын хороо	1.0	Банкны үйл ажиллагааны нэгж тус бүрт үүсч болох эрсдэлийн түвшинг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах, оновчтой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй.	Банкны тухай хуулийн 31.3.1 дүгээр заалт	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх стратеги, бодлогыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн эсэх					Үүнд:Баталсан бодлогын баримт бичгийн огноо дугаар, Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байдал, Эрсдэлийн удирдлагын хорооны тайлант жилд авч хэлэлцсэн асуудлыг жагсааж, түүнийг ТУЗ-д тайлагнасан огноо, шийдвэрлэсэн байдлыг тайлбарлах, Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны эрсдэлийг удирдуулах зорилгоор актив, пассивын удирдлагын хороо эсвэл ижил үүрэгтэй хороодыг байгуулсан эсэх, эдгээр хороод ажлын үр дүнг ТУЗ-д тайлагнасан байдал
22		1.0	ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь банкны дотоод хяналтын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч, сул талыг залруулах, сайжруулах арга хэмжээг тогтмол авч байх үүрэгтэй	Банкны тухай хуулийн 31.3.8 дахь заалт	ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо болон эрсдэлийн удирдлагын нэгжээс банкны дотоод хяналтын тогтолцоонд үнэлгээ дүгнэлт өгсөн байдал					Үүнд: ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороогоор банкны дотоод хяналтын тогтолцооны талаар авч хэлэлцсэн байдал, хурлын тэмдэглэлийн огноо, дугаар, холбогдон гарсан шийдвэр, хямралын төлөвлөгөөг батлуулсан ТУЗ-ийн тогтоолын дугаар, огноо,
23		1.0	Банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлдэг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хянах, МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлдэг эсэх					Үүнд: мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх тогтолцоо бүрдүүлсэн байдал, хэрэгжилтийг хянасан байдал
24	Цалин урамшууллын хороо	1.0	Банкинд мөрдөгдөж буй цалин, урамшууллын бодлогын дагуу ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин, урамшууллын хэмжээг тодорхойлсон байна.	Банкны тухай хуулийн 31.3.1 дэх заалт	Банкны цалин урамшууллын тогтолцоог тодорхойлох бодлогын баримт бичгийг баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд: баталсан бодлогын баримт бичгийн огноо, дугаар, Цалин урамшууллын хороогоор тайлант жилд авч хэлэлцсэн асуудал болон түүнийг шийдвэрлэсэн байдал
25		1.0	Банкны олох ашигт үндэслэн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын хэмжээг тооцоходоо банкны хэтийн стратеги төлөвлөгөөний биелэлт болон банкны үнэ цэнийг өсгөх зорилгыг харгалзан үздэг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын асуудалд банкны ажилтаны ёс зүй, өгөгдсөн ажил үүргийн хэрэгжилтийг харгалзан үздэг эсэх					Үүнд: холбогдох журам болон гэрээний заалт, биелэлтэд хэрхэн хяналт тавьдаг талаар тайлбарлах
26		1.0	ТУЗ нь тус зөвлөлийн нийт гишүүдийн ажлын нэгдсэн гүйцэтгэл болон гишүүн тус бүрийн гүйцэтгэлийг өмнө тогтоосон бэнчмарктай харьцуулан жил бүр үнэлдэг байх	Компанийн тухай хуулийн 81.5.4, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн эсэх,					Үүнд: холбогдох журам, үнэлгээний аргачлал, давтамж, үнэлэх тогтолцооны талаар тайлбарлах

27	Аудитын хороо	1.0	Аудитын хороо нь банкны дотоод хяналтын үйл ажиллагааг дүгнэх, гадаад аудитын цар хүрээг тодорхойлол, гадаад аудит хийх, аудиторыг дэвшүүлэх, батлах, гүйцэтгэх удирдлага болон гадаад аудиторуудтай хамтран жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт хийх үүрэгтэй	Банкны тухай хуулийн 31.3.6 дахь заалт, Компанийн тухай хуулийн 81.4 дэх заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж, дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулдаг эсэх					Үүнд: Аудитын хорооны хурлаар тайлант жилд авч хэлэлцсэн асуудал болон тайлагнасан байдал жагсаах
28		1.0	Банк нь аудитын хорооны шударга, хараат бус байдлыг хангах зорилгоор хорооны гишүүдийн талаас доошгүй хувийг зохистой удирдлага, эрсдэлийн удирдлага болон аудитын талаар гүнзгий мэдлэгтэй, хараат бус, гадны ТУЗ-ийн гишүүдээс бүрдүүлсэн байх	Банкны тухай хуулийн 33.6 дахь заалт, Компанийн тухай хуулийн 81.4 дэх заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилсон эсэх,					Монголбанкнд ТУЗ-ийн хараат бус гишүүний жилд 2 удаа тайлан хүргүүлсэн огноо, албан тоотын дугаар, аудитор сонирхлын зөрчил үүс болзошгүй үед урьчилаад энэ талаар мэдэгсэн эсэх, хууль бус үйлдэл гарсан тохиолдол бүрийг тайлагнах
29		1.0	Банкны хууль тогтоомжийн хэрэгжилт, харилцагчидын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ болон банкны эрсдэлийн удирдлагын өнөөгийн нөхцөлд байдалд тулгуурлан дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, түүнчлэн аудит хийх, давтамж, аудитын цар хүрээ, үр ашгийн талаар талаар нарийвчлан судалсан байх	Банкны тухай хуулийн 31.3.6 дахь заалт, Компанийн тухай хуулийн 81.4 дэх заалт	Аудитын хороо нь банкинд дотоод аудит хийх давтамж түүний цар хүрээ, үр ашгийг тооцон дүгнэж гүйцэтгэх удирдлагад дотоод хяналтын тогтолцооны сул талыг арилах, залруулах талаар чиглэл өгдөг эсэх,					Дотоод аудитын шалгалтын акт материалыг танилцуулсан байдал, дотоод хяналтын тогтолцооны талаар авч авч хэлэлцсэн эсэх, холбогдон гарсан шийдвэр, арга хэмжээ, түүний хэрэгжилтийн талаар
30	Хүний нөөцийн хороо	1.0	Нэр дэвшүүлэх хороо нь хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүлээн авч нэр дэвшигчид нь банкны талаар хууль тогтоомж, ТУЗ-ийн дүрэм, банкны дүрэм, бусад дотоод журамд заасан мэргэжлийн болон бусад асуудлаар тавигдах шаардлагуудыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргах, хэрэв хангаагүй бол нэр дэвшигчдэд хариу мэдэгдэх	Компанийн тухай хуулийн 81.5, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Нэр дэвшүүлэх хороо/хүний нөөцийн хороо нь нэр дэвшүүлэх бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд: Нэр дэвшүүлэх хороогоор тайлант жилд авч хэлэлцсэн асуудал болон холбогдон гарсан шийдвэрийг жагсаах, ТУЗ-өөс баталсан Нэр дэвшүүлэх бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтэд тавих хяналтын талаар тайлбарлах
31		1.0	Банкны гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, тэдэнд холбогдох мэдээллийг цуглуулах, ТУЗ-д танилцуулах болон ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх үүргийг гүйцэтгэнэ.	Компанийн тухай хуулийн 81.5.6 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт өгсөн эсэх					Үүнд: дүгнэлтийг хавсаргах, ТУЗ-д танилцуулсан эсэх
32	ТУЗ-ийн тайлагналт	1.0	ТУЗ нь гаргасан шийдвэр, өөрийн үйл ажиллагаа хувьцаа эзэмшигчид тогтмол тайлагнаж түүндээ ТУЗ-ийн гишүүдийн хурлын иршийн асуудлыг хамруулсан байна.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ нь өөрийн жилийн үйл ажиллагааны үр дүнг хувьцаа эзэмшигчид тайлагнадаг эсэх					Үүнд: тайлагнасан хурлын тэмдэглэлийн огноо, дугаар, давтамж,
33	Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ	1.0	Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл болон гэрээний биелэлтийг тогтмол үнэлж, дүгнэлт өгдөг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлж, дүгнэлт өгдөг эсэх					Үүнд: хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан эсэх, гэрээний биелэлт, ажлын гүйцэтгэлийн үнэлэх аргачлал, үнэлгээ өгсөн байдал
НИЙТ ДҮН		33.0					33.0		33.0	

III. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	
1	Засаглалын зарчмыг бүрдүүлэх	1.0	Банкны гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого, дүрэм, журмын, хэрэгжилтийг хангах зорилгоор банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах дүрэм, журам боловсруулж, түүнд үнэлэлт, дүгнэлт өгч, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	Компанийн тухай хуулийн 83.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө болон бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг тогтоож, түүнийг тогтмол эргэж хянадаг эсэх					Үүнд: Засаглалын зарчим бүрдүүлсэн байдал
2	Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг бүрдүүлэх	1.0	ГУ нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор багын гишүүдтэй ажиллаж дотоод журмыг боловсруулсан байх. Ажилтанууд бие биенийхээ ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах аргачлалыг нэвтэрүүлэх үүрэгтэй. Банкны удирдлага зохион байгуулалт, банкинд хэрэгжих тогтолцоог бүрдүүлэхдээ банкны ажилтануудыг сонирхлын зорчилд орохоос сэргийлэх байдлыг хангана.	Банкны тухай хуулийн 34.2 дахь заалт, Компаний тухай хуулийн 83.10 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн удирдлага, банкны ажилтнуудын эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл болон хариуцлага тооцох арга зэргийг тодорхойлж, түүнийг тогтмол эргэж хянадаг эсэх					Үүнд: Ажилтанууд бие биенийхээ ажлын гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоо, банкны ажил үүрэгт тохирсон боловсон хүчнийг хуваарилсан байдал, банкны ажилтануудын эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлага, хариуцаж буй ажлаа удирдах, хяналт тавихад шаардагдах мэдлэг чадвар, туршлага, холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн журамласан байдал, түүний гүйцэтгэлд үнэлгээ дүгнэлт өгөх тогтолцоог тайлбарлах, мөнгөн угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого журмын хэрэгжилтийг хянах нэгж байгуулсан эсэх
3	Гүйцэтгэх удирдлагын ажлын чадвар, туршлага	1.0	Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүн бүр өөрийн хариуцсан ажлаа удирдах, түүнд хяналт тавих банк санхүү эдийн засгийн мэдлэгтэй, удирдах чадвартай, мэргэжлийн дадлага туршлагатай байх шаардлагатай. Банкны гүйцэтгэх удирдлагад тавигдах ажлын туршлага туршлага, удирдах чадвард шалгуурыг тодорхойлж, журмын дагуу сонгон шалгууралалтын хийж, Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшөөлсний үндсэн дээр томилох үүрэгтэй	Банкны тухай хуулийн 31.3.2 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага болон мэргэжлийн чадварт шалгуур тавих шалгуур хангасан байдалд үнэлгээ дүгнэлт өгдөг эсэх					Үүнд: тавигдах шалгуур, хангасан байдал, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд удирдах чадварыг уялдуулдаг эсэх, үнэлгээ дүгнэлт өгдөг эсэх
4	Хяналтын тогтолцоог бүрдүүлэх	1.0	Банкинд үр ашигтай дотоод хяналтын тогтолцоог нэвтэрүүлэх нь гүйцэтгэх удирдлагын чухал үүргийн нэг бөгөөд банкны үйл ажиллагааны нэгж тус бүрт үүсэх эрсдэлийг үнэлэх замаар нэгж тус бүрт тохирох дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байх	Банкны тухай хуулийн 34.1.7 дэх заалт	Банкны хэвийн ажиллагааг хангахуйц дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсөн тохиолдолд удирдлагуудад танилцуулж, зохих арга хэмжээг авдаг эсэх					Үүнд: Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байдал, Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүсэх, үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсөн тохиолдолд мэдээлэх, тайлагнах, арга хэмжээ авах тогтолцоог тайлбарлах,

ТӨСӨЛ

5	Дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх	1.0	Банкны хэвийн ажиллагааг хангахуйц дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх. Банкны үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг хангаж ажилласан байдалд дотоод аудитын нэгжээр үнэлүүлэхээс гадна давхар гүйцэтгэх удирдлагын харьяа хяналтын нэгжээр үнэлүүлж, дүгнэлт өгч ажиллах нь зүйтэй	Банкны тухай хуулийн 34.1.7 дахь заалт	Банкны дотоод хяналтын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч ажилладаг эсэх				Үүнд: Дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгдөг эсэх, мөн үр дүнгийн талаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнаж, тодорхой арга хэмжээ авсан байдал
6	Эрсдэлийн түвшинд тавих хяналт	1.0	Банкны эрсдэлийн удирдлагын талаарх болон бусад шаардлагатай гэж үзсэн дотоод дүрэм, журам, зааврыг боловсруулж, банкны үндсэн эрсдэлүүдэд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачлага гарган ажиллах, банкны үйл ажиллагааны онцлог болон хүлээж болзошгүй эрсдэлийн нэр төрөлтэй уялдуулан удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэлийн төрөл тус бүрт тавих хяналтын тогтолцоог бүрдүүлсэн эсэх				Үүнд: Гүйцэтгэх удирдлагын хороодыг байгуулж, түүний ажиллах журмыг баталсан огноо, дугаар. Эрсдэлийн төрөл тус бүрийн үйл ажиллагааг зохицуулах журам, түүний хэрэгжилтийн байдал, эрсдэлийн төрөл тус бүрт тавих хяналт, мэдээлэх тайлагнах, шийдвэр гаргах, үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хянах тогтолцоог тайлбарлах
7	Тайлан, тэнцрэл, мэдээ, судалгааг үнэн зөв эсэхийг хянах тогтолцоо бүрдүүлэх	1.0	Гүйцэтгэх удирдлагад ирүүлсэн хууль журмын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл үнэн зөв эсэхийг хэрэгжилт хариуцсан ажилтан болон нэгжийн удирдлагаар хянаж баталгаажуулдаг байх. Банкнд сөргөөр нөлөөлөх хууль бус үйлдлийн талаар хэрэгжилт хариуцсан нэгж болон ажилтанаар шалгуулж, эсхүл гуравдагч талуудаас бүрдүүлсэн багаар шалгуулж, тайланг удирдлагуудад танилцуулсан байх	Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Хууль тогтоомжийн хэрэгжилт болон банкны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн үнэн зөв эсэхийг шат дараалсан хяналтаар хянаж, баталгаажуулдаг эсэх				Үүнд: Шат дараалсан хяналт, баталгаажуулах тогтолцоог бүрдүүлсэн байдал, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог тайлбарлах
8	Хуулийн хэрэгжилтийг хянах	1.0	Банкны гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлсэн байна.	Банкны тухай хуулийн 34.1.5 дэх зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкинд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх				Үүнд: Хууль журмын хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлсэн байдал, банкны үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг бусад хууль, эрх зүйн акттай нийцэж байгааг хянадаг эсэх, хуулийн хэрэгжилтийг хянах нэгж байгуулсан эсэх, ажил үүргийг тодорхойлсон эсэх
9	Ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх	1.0	Гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд банкны эрхэмлэх үнэт зүйлс, хууль, журмын хэрэгжилт, банкны эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалтууд болон бусад хэм хэмжээг хангасан байдлыг ажлын гүйцэтгэлийг үнэлэх стандартад тусгаж үнэлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Мөн банкны ажиллагсад эрх үүргээ зүй ёсоор биелүүлэх зорилгоор шагнал урамшуулал олгох, шийтгэл ногдуулах тогтолцоог бүрдүүлсэн байна	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог бүрдүүлж, шагнал урамшууллын тогтолцоог банкны хэтийн зорилго, үйл ажиллагааны үр дүн болон ёс зүйн хэм хэмжээтэй уялдуулсан эсэх				Үүнд: Банкны ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх,шагнал урамшуулал олгох, сахилгын шийтгэл ногдуулах тогтолцоог бүрдүүлсэн байдал, банкны нийт ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан эсэх,
10	Гүйцэтгэх удирдлагын тайлагналт	1.0	Гүйцэтгэх удирдлага ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө, бодлого журмын хэрэгжилт болон эрсдэлийн удирдлагын өнөөгийн нөхцөл байдлын талаар тодорхой давтамжит хугацаанд мэдээлдэг байх	Банкны тухай хуулийн 32 дугаар зүйл, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	ТУЗ-д хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлийн удирдлагын өнөөгийн байдлын талаар тогтмол мэдээлж, гүйцэтгэх удирдлагын 23-ын үүргийн биелэлтийн талаар тайлагнах тогтолцоо бүрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх				Үүнд: ТУЗ, түүний дэргэдэх хороодыг мэдээллээр хангах, тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн байдал, гүйцэтгэх удирдлагын үүргийн хэрэгжилтийн талаар тайлагнасан байдал, үнэлгээ дүгнэлт /энэ талаар хэлэлцсэн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийн огноо дугаар/

11	Мэдээллийн системийн удирдлагын тогтолцоо	1.0	Банкны стратеги төлөвлөгөөнд үндэслэн мэдээллийн системийн бодлого, төлөвлөлт, төсвийн тоцоолол, удирдлагын тогтолцоо шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх. Банкны нууцал хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоож, түүнийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн байна.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмын зөвлөмжийн 4.2.9 дэх заалт	Мэдээллийн системийн найдвартай ажиллагаа, эрсдэлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлсэн эсэх					Үүнд: батласан бодлогын баримт бичгийг огноо дугаар, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам, түүний хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо, мэдээллийн системийн эрсдэлийг үнэлэх, хяналт шалгалт хийсэн байдлыг тайлбарлах. Банкны нууцал хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоож, аюулгүй байдлыг хангах журам баталсан огноо, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлсэн байдал, түүний хэрэгжилтийг хянах, тайлагнасан байдал
12	Харилцагчийн эрх ашгийг хамгаалах	1.0	Банк, банкны харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавих, банкны гүйцэтгэх удирдлага үүрэг гүйцэтгэх явцад олж авсан банкны харилцагчийн талаарх мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.	Банкны тухай хуулийн 34.1.1, 34.1.2 дахь заалт,	Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажилладаг эсэх					Үүнд: Журам баталсан огноо, дугаар, Журамд харилцагчдаа таньж мэдэх, бизнесийн төрөл, банкны бүтээгдэхүүн болон бусад холбогдох мэдээллийг өгөх аргачлал, харилцагчийн зүгээс ирүүлсэн санал дүгнэлтийг хүлээн авах, холбогдох арга хэмжээ авах талаар, харилцагчийн мэдээллийг хадгалах, аюулгүй байдлыг хангах талаар тус тус тусгасан байдал. тайлагнах болон үнэлгээ дүгнэлт өгөх тогтолцооны талаар тайлбарлах
13	Ашиг сонирхлын зөрчил	1.0	Банкны ажилтан албан үүргээ ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх талаар урьдчилан мэдэгддэг байх.	Банкны тухай хуулийн 34.1.4, 34.1.6 дахь заалтууд, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны ажилтны ашиг сонирхлын зөрчлийг бууруулах тогтолцоо бүрдүүлсэн эсэх					Үүнд: Холбогдох журам, заавар. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн тохиолдлыг мэдэгдэх, мэдээллийг хүлээн авах, тайлагнах, шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар тусгасан байдал, Ажилтан бүрийг албан үүргээ ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөл бүрдүүлсэн байдал,
14	Мөнгө угаах терроризмтэй тэмцэх	1.0	Мөнгө угаалтын асуудал хариуцсан ажилтан томиж, ажлын үр дүнгийн талаар ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон холбогдох эрх бүхий байгууллагад тайлагнадаг байх	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1 дэх заалт	Мөнгө угаалтын асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтныг томиж, түүний ажил үүргийн биелэлтэд хяналт тавьдаг эсэх					Үүнд:Томилгогдсон тушаалын огноо, дугаар, ажил үүргийн хуваарь, түүний биелэлтэд хэрхэн хяналт тавьдаг талаар тайлбарлах
15		1.0	Мөнгө угаалтын эсрэг арга хэмжээний талаар учирч болох эрсдэлийг үнэлэг аргачлалыг боловсруулж, үнэлгээний үр дүнг удирдлагуудад танилцуулах, Банк нь мөнгө угаалттай холбоотой сэжигтэй гүйлгээ болон харилцагчийг таньж байгаа талаар холбогдох газар хэлтэс, ажилтнуудад сургалт зохион байгуулах, зөвлөмж өгөх, сэжигтэй гүйлгээнд тавигдах шалгуур нь оновчтой эсэх талаар хяналт тавих.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1, 14.1.3 дахь заалт	Мөнгө угаалтын эсрэг авах арга хэмжээний хүрээнд харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнг удирдлагад танилцуулсан эсэх					Үүнд: эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж, үнэлгээ хийсэн тайланг банкны удирдлага болон Монголбанкны СМА-д тайлагнасан байдал, Банкны ажилтнуудад мөнгө угаалтын талаар зохион байгуулсан сургалт, боловсруулсан зөвлөмжийн талаар тайлагнах
16	Цалин урамшууллын тогтолцоо	1.0	Ажиллагсдын цалин урамшууллын систем нь ажлын гүйцэтгэл болон нийт гүйцэтгэлтэй нягт уялдах хэрэгтэй. Цалин урамшуулал, хангамж олгох болон холбогдох сангаас зарцуулалт хийх үйл ажиллагааг журамласан байх.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлж, журмын дагуу сангаас зарцуулалт хийгдсэн эсэх					Үүнд: Ажиллагсад болон гүйцэтгэх удирдлагад цалин урамшуулал, тэтгэмж болон бусад хангамж олгох асуудлыг ажлын гүйцэтгэлийг нийт гүйцэтгэлтэй уялдуулсан байдал, цалин урамшуулал олгох, холбогдох сангаас зарцуулалт хийх үйл ажиллагааг журамласан байдал, хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьдаг талаар тайлагнах.
НИЙТ ДҮН		16.0				16	16.0	16	16.0	

IV. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТ										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	
1	Эрсдэлийн удирдлагын алба	1.0	ТУЗ-өөс байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын нэгдсэн чиг үүргийг хэрэгжүүлэх эрсдэл хариуцсан алба байгуулсан байх. Алба нь гүйцэтгэх дээд удирдлагад тайлагнахын зэрэгцээ ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороонд тайлагнах, мөн саад хүндрэлгүйгээр шууд харьцах эрхтэй байна.	Банкны тухай хуулийн 31.3.1 дэх заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банк нь эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх алба байгуулж, түүнийг ажиллах бодлого, заавар журмыг баталсан эсэх					Үүнд: алба байгуулсан болон ажиллах журмыг баталсан тушаалын огноо, дугаар
2	Эрсдэлийн удирдлагын нөөц бололцоо	1.0	Эрсдэлийн удирдлагын алба нь хүний нөөц, мэдээллийн технологийн системийн ашиглалт, системийг хөгжүүлэх, дотоод мэдээллийг ашиглах, дэмжих зэргийг багтаасан эрсдэлийг үнэлэхэд шаардагдах хүн хүч, хөрөнгө нөөцтэй байх ёстой.	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэлийн удирдлагын албыг банкны бизнесийн болон гүйцэтгэх үйл ажиллагаанаас хараат бусаар зохион байгуулж, хангалттай эрх мэдэл, байр суурь, хөрөнгө нөөцтэй, ТУЗ-тай шууд харьцах эрхээр хангасан эсэх					Үүнд: , бүтэц, зохион байгуулалт, албанд ажиллах албан тушаалтанд тавигдах шаардлага, нөхөн олговор болон бусад урамшууллын асуудал, банкны дотоод мэдээллийн системд нэвтрэх эрхийг тусгасан заалт, тайлагналын тогтолцоо зэргийг тайлбарлах
3	Эрсдэлийн удирдлагын чиг үүрэг	1.0	Эрсдэлийн удирдлагын алба нь эрсдэл тус бүрт тухайлсан бодлоготой байж, үйл ажиллагаа, эрсдэлийг үнэлэх аргачлалыг тодорхойлон, түүнд шаардагдах хэрэгцээт хөрөнгийг төлөвлөх, эрсдэл хүлээх шийдвэр гаргуулах, түүний хэрэгжилтийг хянах үүрэгтэй	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкинд үүсч болох эрсдэлийг нээн илрүүлэх, түүнийг эсрэг арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлсэн эсэх,					Үүнд: (1) Журмын заалт, Чиг үүргийн хэрэгжилт: (1)Бизнесийн үйл ажиллагааны чиглэл тус бүрт учир болох эрсдэлийн түвшинг тодорхойлсон эсэх, (2) эдгээр эрсдэлийг үнэлэх, тооцох аргачлалыг тодорхойлж, шаардах хөрөнгийн хэмжээг төлөвлөж, гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д таниуулан эсэх, (3) Эрсдэл хүлээх шийдвэр нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн бодлогод нийцж байгаа эсэхийг хянасан, мөн дээрх эрсдэлийн үр дагаварыг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, шийдвэр гаргах удирдлагуудад ойлгуулсан байх, (4)Стресс тест хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авдаг эсэх,
4	Эрсдэлийн удирдлагын газрын захирал	1.0	Эрсдэлийн удирдлагын газрын захирлыг гүйцэтгэх удирдлагын бусад чиг үүрэг, бизнесийн үйл ажиллагаанаас хараат бусаар томилж, ажил үүргийн хуваарийг тодорхойлсон байна.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэл хариуцсан захирлыг гүйцэтгэх удирдлагын бусад чиг үүрэг, бизнесийн үйл ажиллагаанаас хараат бусаар зохин байгуулж, эрсдэлийн удирдлагын нэгдсэн чиг үүргийг хэрэгжилтийн талаар ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороонд давтамжтай тайлагнадаг эсэх					Үүнд: Томилсон тушаалын огноо, дугаар, эрх үүргийн тодорхойлсон байдал,ТУЗ-ийн дэргэх эрсдэлийн хороонд тайлагнасан байдал,
5		1.0	Эрсдэлийн удирдлагын захирал нь тухайн эрсдэлийн банкинд авчрах үр дагаварыг үнэлэх, дүгнэх чадвартай байх, мөн үнэн, зөв, бүрэн бүтэн мэдээллээр хангагдсан байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэлийн удирдлага хариуцсан ажлын багийн ашиглаж буй Гүйцэтгэх удирдлага банкны зохисой засаглалын тогтолцоог бүрдүүлэхэд дараах эрх, үүргийг хэрэгжүүлэх:сэх					Үүнд: Эрсдэлийн удирдлагын газрын захиралд тавигдах шалгуур, түүнийг хангасан байдал, мэргэшсэн байдал, эрсдэлийн удирдлагын газар үнэн, зөв, бодит мэдээллээр хангагдах тогтолцоо бүрдсэн эсэх,

6	Нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалт	1.0	Банкны эрсдэлийн түвшин нь гадаад орчноос хамааран байнга өөрчлөгдөж байдаг тул эрсдэлийн удирдлагын алба нь банкинд учирч болох эрсдэлийг илрүүлэх. Групп болон салбар компаниудад учирч болох эрсдэлийг нэгдсэн болон хэсэгчилсэн байдлаар тогтоох.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэлийн удирдлагын албанаас банкинд учирч болох эрсдэлийг нээн илрүүлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн байдлаар эрсдэлийг тогтоосон эсэх					Эрсдэлийг илрүүлэх болон хянах тогтолцооны талаар тайлбарлах, эрсдэлийг нэгдсэн болон хэсэгчилсэн тогтоосон эсэх
7	Эрсдэлийн шинжилгээ	1.0	Банкны эрсдэлийн түвшин болон түүнд холбогдох мэдээллийг цуглуулж, шинжилгээ хийж, тодорхой хугацаанд давтамжтайгаар эсвэл шаардлагатай бол тухай бүр удирдлагуудад танилцуулан тайлагнаж байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны өнөөгийн байдал болон эрсдэлийн түвшингийн талаар шинжилгээ хийж, удирдлагуудад танилцуулж, тайлагнадаг эсэх					Үүнд: Эрсдэлийн шинжилгээ хийх, үнэлэх тогтолцоо, Актив пассивын хороо, эрсдэлийн хороо, зээлийн хороо зэрэг гүйцэтгэх удирдлагын хороо байгуулсан эсэх, тэдгээрийн үйл ажиллагааны журам боловсруулсан эсэх, эдгээр хороодыг мэдээллээр хангаж, шийдвэр гаргах тогтолцоо, тайлагнасан байдал,
8		1.0	Эрсдэлийн нэгдсэн үнэлгээ хийхэд банкны салбар, нэгж болон голлох харилцагч байгууллага болон бизнесийн чиглэл бүрээр эрсдэлийг үнэлдэг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Эрсдэлийн үнэлгээг хийхдээ томоохон харилцагчийн үйл ажиллагааны онцлог, салбар нэгж болон бизнесийн чиглэл бүрээр эрсдэлийг үнэлсэн эсэх					Үүнд: нэгдсэн болон нэгж бүрт хийх эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, харилцах, хадгалмжийн гадаад дотоод урсгалд тавигдах хязгаарлалтууд, зээлийн төвлөрөлд тавигдах хязгаарлалтууд, түүний хэрэгжилтийг хянах тогтолцоо, мэдрэмтгий байдлын шинжилгээ хийсэн байдал
9	Шинэ бүтээгдэхүүн	1.0	Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, бизнес төлөвлөгөө батлуулж, зах зээлд гаргах шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоож, шинэ бүтээгдэхүүн нь дээрх шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, учирч болох эрсдэлийг шинжлэх, үнэлэлт дүгнэлт өгдөг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкнаас зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргахын өмнө учирч болох эрсдэлийн талаар шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх					Үүнд: Зах зээлд гаргах шинэ бүтээгдэхүүний талаарх бизнесийн орчинг судалж, бизнес төлөвлөгөөг батлуулсан, шинэ бүтээгдэхүүнд тавигдах шалгуурыг хянах ажилтан томилсон, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхэд учирч болох эрсдэлийн талаар шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн байдал, удирдлагуудад тайлагнасан байдал
10	Эрсдэлийн удирдлагад үнэлгээ, дүгнэлт өгөх	1.0	Дотоод аудитын төлөвлөгөөнд (1) эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны одоогийн нөхцөлд байдал, эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлого, дотоод журмын хэрэгжилт, банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийн түвшингэй уялдсан эсэх, банкны нэгдсэн эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй аргачлалын сул тал, хязгаарлалт, тооцооны нарийвчлал, ашиглаж буй мэдээллийн найдвартай үнэн зөв эсэх, стресс тестэд ашиглаж буй сценари оновчтой эсэх, өмнөх аудитаар өгсөн санал дүгнэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгсөн байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын албанаас банкны эрсдэлийн удирдлагад аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн байдал					Үүнд: Аудит хийсэн огноо, давтамж, шалгалт хамарсан цар хүрээ, өгсөн санал дүгнэлт, үр дүнгийн талаар тайлбарлах, аудитын дүгнэлтийг удирдлагын хороогоор авч хэлэлцсэн байдал
11	Хүндрэлийг арилгах төлөвлөгөө боловсруулах	1.0	Банкинд ноцтой хохирол учруулах хямралын үед авах арга хэмжээ болон бизнесийг тасралтгүй явуулах төлөвлөгөө боловсруулсан байх	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын зөвлөмж	Банкинд үүсч болох хямралыг нээн илрүүлэх, хүндрэлийг арилгах төлөвлөгөө боловсруулсан эсэх					Үүнд: төлөвлөгөө батлуулсан огноо, дугаар, Монголбанкнд хүргүүлсэн байдал

ТӨСӨЛ

12		1.0	Банкны эрсдэл тус бүрт тухайлсан бодлоготой байж, тэдгээрийн үйл ажиллагааг тодорхойлох, мөн түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Банкны үйл ажиллагааны нэгж тус бүрт үүсэх эрсдэлийг үнэлэх замаар нэгж тус бүрт тохирох хяналтыг бүрдүүлсэн байна.	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын зөвлөмж	Эрсдэлийн удирдлагын албанаас банкны зээлийн, зах зээлийн, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад бизнесийн эрсдэлийг тодорхойлох, мөн нэгж тус бүрт үүсэх эрсдэлийг үнэлэн түүнд тохирох хяналтыг бүрдүүлсэн эсэх					Банкны удирдлага нь банкны үйл ажиллагаа болон түүний эрсдэлийн түвшинг хянах хяналтын орчинг бүрдүүлсэн байх, Үүнд: Эрсдэлийн үнэлгээ, хяналтын арга хэрэгсэл, мэдээлэх, хяналтын үнэлгээ холбогдон гарсан дүрэм, журмын зохицуулалтын талаар тайлбарлах,
13	Дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх	1.0	Банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагуудыг банкны үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллээр хангах, мөн банкны үйл ажиллагааны чиглэл бүр/ газар, хэлтэс/-ийг банкны үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах. Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагын хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсөн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах үүрэгтэй	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны үйл ажиллагааны чиглэл тус бүр /газар, хэлтэс/-ийн хооронд мэдээлэл солилцох, мэдээлэх хэвтээ механизм, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангах, мэдээлэх босоо механизмыг бүрдүүлсэн байдал					Мэдээлэл солилцох, мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байдал. Үүнд холбогдон гарсан дүрэм, журам, түүнийг хэрэгжилтийг хянах тогтолцооны талаар тайлбарлах
		13.0					13.0		13.0	

V. ДОТООД АУДИТ											
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/	
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ		
1	Дотоод аудитын нэгжийн хараат бус байдал	1.0	Банкны ТУЗ нь дотоод аудитын нэгжийг газрын гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, үүний төсөв, орон тоог, батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоосон байх	Банкны тухай хуулийн 31.3.6 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын газрын гүйцэтгэх удирдлагаас хараас бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог, батлах, удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллын хэмжээг тогтоосон эсэх					Дотоод аудитын газрын төсөв, орон тоог баталсан, захирал болон бусад ажилтныг томилсон тушаал, цалин урамшууллын хэмжээг тогтоосон тушаалын огноо, дугаар,	
2	Аудитын бодлого	1.0	Дотоод аудитын ажиллах журмыг ТУЗ-өөр батлуулсан байх. Бодлогын баримт бичигт дотоод аудитын зорилго, дотоод аудитын нэгжийн хараат бус байдал, дотоод аудитын нэгжийн эрх, үүрэг хариуцлага, шаардлагатай мэдээллийг авах болон дотоод аудитыг сайжруулах тогтолцоо, дотоод аудитын тайлан мэдээг хүргүүлэх, тайлагнах тогтолцоо зэргийг тусгасан.	Банкны тухай хуулийн 31.3.8 дахь заалт,Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын нэгжийн ажиллах журмыг боловсруулж, мөрдөж ажилласан эсэх					Дотоод аудитын газрын ажиллах журмыг баталсан тогтоолын огноо дугаар, Дотоод аудитын нэгжийн хараат бус байдал, дотоод аудитын нэгжийн эрх, үүрэг хариуцлага, дотоод аудитын тайлан мэдээг хүргүүлэх, тайлагнах тогтолцоо, аудит хийх аргачлал, шалгах стандарт зэргийг тус тус тусгасанбайдал	
3	Дотоод аудитын төлөвлөгөө	1.0	Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа банкинд хийгдэх хугацааны давтамж, үр нөлөө, аудит хийж буй нэгжийн эрсдэлийн удирдлага, хариуцагчдын эрх ашгийг хамгаалах болон хууль журмын хэрэгжилтийн талаар тусгасан байна. Аудитын төлөвлөгөөний хуваарь өөрчлөлт оруулахад банкны ТУЗ болон аудитын хорооноос зөвшөөрөл авсан байна.	Банкны тухай хуулийн 31.3.6 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажилласан эсэх					Дотоод аудитын төлөвлөгөөг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор хянуулж, батлуулсан байдал	
4	Шалгалтын удирдамж болон ажлын баримт	1.0	Аудитын хөтөлбөрт аудитын зорилго болон аудит хийсэн аргачлалыг тусгасан байх, хөтөлбөрт ажил гүйцэтгэгч болон үнэлэлт, дүгнэлт өгсөн эзнийг тодотгосон байх, аудитын ажлын баримтад аудиторын баримт нотолгоо болон түүнд үндэслэн хийгдсэн дүгнэлт, аудитын үйл ажиллагаанаас илэрсэн тулгамдаж буй асуудлыг тодорхой тусгасан байх.	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын шалгалтын удирдамжид аудитын зорилго болон аудит хийх аргачлалыг тусгасан эсэх,					Дотоод аудитын газраас шалгалт, хийсэн огноо, шалгалтын зорилго, шалгасан асуудлыгжагсаалтыг ирүүлэх	
5	Эрсдэлийн үнэлгээ	1.0	Банкны эрхлэх үйл ажиллагаа, тэдгээрт харгалзах эрсдэл, нөлөөлдөг хүчин зүйлийн талаар аудитын дүгнэлтэд тусгасан байх. Мөн эрсдэлийн үнэлгээнд банкны тухайн үеийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, эрсдэлийг удирдсанаар хэдий хэмжээний эрсдэлийг бууруулсан, үлдэж буй банкны хүлээх эрсдэлийн хэмжээ зэргийг тодорхой тусгасан байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудит нь эрсдэлийг илрүүлэх үйл ажиллагаанд чиглэгддэг эсэх					Эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх, өгсөн үүргийн биелэлтийг хянах тогтолцоог талаар тайлбарлах	

6	Аудитын тайлан	1.0	Аудитын тайланд шат дараалсан хяналт тавьж, дотоод аудитын газрын захирал, гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн аудитын хороогоор танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг тусгасан байх. Аудитор нь банкинд буй эрсдэлийг нээн илрүүлж, үнэлгээ дүгнэлт өгөх, банкны дотоод хяналтын тогтолцоо үр ашигтай байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөх чадвар, туршлага байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Аудитын тайланг дотоод аудитын газрын захирал, гүйцэтгэх удирдлага, аудитын хороо болон ТУЗ-д танилцуулдаг эсэх,					Үүнд: Аудитын тайланг дотоод аудитын газрын захирал, гүйцэтгэх удирдлага, аудитын хороо болон ТУЗ-д танилцуулсан байдал
7	Дотоод аудиторуудын мэдлэг чадвар	1.0	Дотоод аудиторуудын үүрэг харицлага, боловсролын түвшинд тавигдах шаардлагыг дотоод аудитын газрын дүрэм/журам-д тодорхой заасан байна. Аудитор нь тухайн нэгжид аудит хийх хангалттай мэдлэг туршлагатай, оногдсон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдэлтэй байх, мөн дотоод аудиторыг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод аудиторыг тасралтгүй сургах тогтолцоог бүрдүүлсэн байх, дотоод аудиторын бие даасан, хараат бус байдал хангагдсан байх	Банкны тухай хуулийн 31.3.6 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудиторт тавигдах боловсролын түвшин, ажлын ур чадвар, ёс зүй, үүрэг хариуцлага, эрх мэдэл болон бусад шалгуурыг тавьж, хэрэгжилтийг хангасан эсэх					Үүнд: Дотоод аудиторт тавигдах шаардлага, холбогдох заалт, одоогийн аудиторууд дээрх шаардлагыг хангаж байгаа байдал
8		1.0			Дотоод аудиторын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод аудитораа тасралтгүй сургах тогтолцоог бүрдүүлсэн эсэх					Тайланг жилд дотоод аудиторуудыг сургалтад хамруулсан байдал
9	Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	1.0	Дотоод аудитын шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, алдаа дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх, өмнөх шалгалтаар өгсөн үүргийн биелэлтийг дараагийн аудитын шалгалтын удирдамжид тусгадаг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Дотоод аудитын шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх,					Дотоод аудитын шалгалтаар авсан арга хэмжээний биелэлтэд тавих хяналтын тогтолцоо, биелсэн байдал
10	Тайлагнах тогтолцоо	1.0	Дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт, материал, ажлын тайлан, банкны үйл ажиллагаа болон дотоод хянагын тогтолцооны хэрэгжилтэд үнэлэлт өгч, ТУЗ болон гүйцэтгэх удирдалагад тайлагнадаг байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны зохистой засаглал, хяналтын үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага болон бусад үйл ажиллагаа нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлгээ дүгнэлт өгч, тодорхой давтамжтайгаар тайлагнасан эсэх					ТУЗ болон гүйцэтгэх удирдалагад тайлагнах тогтолцоог тайлбарлах, ТУЗ-д давтамжтай тайлагнасан байдал
		10.0					10.0		10.0	

VI. ХӨНДЛӨНГИЙН АУДИТ										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигтэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигтэсэн үнэлгээ	
1	Жилийн санхүүгийн тайлан баталгаажуулах	1.0	Банк, банкны толгой компани, тэдгээрийн хараат болон охин компани нь санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт бичгээ аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа шалгуулж баталгаажуулж байх	Банкны тухай хуулийн 40.1 дүгээр зүйл, Аудитын тухай хуулийн 5.8, 7.1.7 дахь заалт, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банк нь жилийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд, стандартын дагуу эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн аудитын байгууллагаар баталгаажуулдаг эсэх,	2	1.0	2	1.0	Тайлан батлагаажуулсан байгууллагын нэр, баталгаажуулсан санхүүгийн тайланг Монголбанкнд хүргүүлсэн байдал
2	Аудит хийх байгууллага болон аудиторт тавигдах шаардлага	1.0	Банкинд хөндлөнгийн аудит хийж буй аудитор нь мэргэжлийн болон банкнаас тавих шалгуур, стандартыг хангасан байх. Аудитор нь банкны өмнө хүлээх үүргээ бүрэн ухамсарлаж, аудитыг мэргэжлийн түвшинд хийдэг байх	Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйл,Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкинд хөндлөнгийн аудит хийж буй аудитор нь мэргэжлийн болон бусад шалгуурыг хангасан эсэх олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эсэх,	2	1.0	2	1.0	Банкнаас хөндлөнгийн аудитын байгууллагад тавигдах шаардлага, аудиторт тавигдах шалгуур, сонгон шалгаруулах аргачлал
3	Эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт	1.0	Банкинд аудит хийж буй тохиолдолд банкны үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлж, дүгнэлт өгөх үүрэгтэй. ТУЗ-өөс гаргасан бодлого, журмын хэрэгжилтийг гүйцэтгэх удирдлагаас хэрхэн биелүүлж байгаа талаар үнэлгээ дүгнэлт өгөх	Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйл болон Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкинд аудит хийж буй тохиолдолд банкны үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн эрсдэлийг үнэлж, дүгнэлтийг эрх бүхий байгууллагад мэдээлдэг эсэх,	2	1.0	2	1.0	Банкны үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн талаар өгсөн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах, эрх бүхий байгууллагад мэдээлсэн байдал
4	Мэдээ, мэдээлэл нь үнэн зөв эсэхийг нягтлах	1.0	Банкнаас гаргаж өгсөн аливаа мэдээ, мэдээлэл, баримт материал нь үнэн зөв эсэхийг нягтлан шалгах. ТУЗ, хувьцаа эзэмшигч болон хяналт шалгалтын байгууллагуудад шаардлагатай мэдээллийг үнэн, бодигоор хүргүүлж байгаа эсэхийг нягтлах	Банкны тухай хуулийн 40 дүгээр зүйл, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкнаас аудитын хүрээнд гаргаж өгсөн аливаа төрлийн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв эсэхийг магадлан шалгаж, баталгаажуулсан эсэх, аудитын дүгнэлт гарсан эсэх	2	1.0	2	1.0	Мэдээлэл нь үнэн зөв эсэхийг магадлан шалгаж, энэ талаар аудитын дүгнэлтэд тусгасан байдал, хязгаарлалттай дүгнэлт гарсан бол шалтгаан нь
5	Тайлагнасан байдал	1.0	Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлт болон хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн баталж, дүгнэлт гарган Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж, батлуулах үүрэгтэй	Банкны тухай хуулийн 40.2 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 62.1 дэх зүйл,Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны жилийн санхүүгийн тайлан, баримт бичгийн талаарх дүгнэлтийг банкны ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулсан эсэх	2	1.0	2	1.0	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлаар танилцуулсан хурлын тэмдэглэлийн огноо, дугаар, баталсан байдал, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын дүгнэлтийг хавсргах,
6	Залруулгын гүйлгээ	1.0	Хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу хийгдэх тохи руулгын гүйлгээг цаг хугацаанд нь үнэн зөв хийсэн байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Аудитын залруулгын гүйлгээг цаг хугацаанд, үнэн зөв хийсэн эсэх	2	1.0	2	1.0	Аудитын залруулга хийсэн огноо, дугаар, гүйлгээнвий утга
		6.0					6.0		6.0	

VII. ИЛ ТОД БАЙДАЛ										
	Гарчиг	жигнэх хувь	Зохистой засаглалын зарчим	Хууль, журмын заалт	Асуулт	Банкны үнэлгээ		Хянан шалгагийн		Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх/
						Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Жигнэсэн үнэлгээ	
1	Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл	1.0	Хувь эзэмшигчдийн бүтцийн талаарх мэдээллийг банкны цахим хуудсанд байршуулж, өөрчлөлт гарсан тохиолдол бүрд шинэчлэлт хийж байх үүрэгтэй. Мөн хувь нийлүүлэгчдийн бүтцийг эцсийн эзэмшигч хувь хүн хүртэлх задалж, мэдээллийг банкны цахим хуудсанд ил тод толилуулах нь зүйтэй.	Банкны тухай хуулийн 38.2.4 дахь заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны цахим хуудсанд хувьцаа эзэмшигчдийн бүтэц, нөлөө бүхий хувь эзэмшигчдийн талаарх мэдээллийг мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг банкны цахим хуудсанд мэдээлсэн байдал
2	Банк эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл	1.0	Банкны ТУЗ-ийн дарга, гишүүд, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийн талаарх мэдээллийг банкны цахим хуудсанд мэдээлсэн байх. Банкны хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтантай холбоотой хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлын талаарх мэдээллийг толилуулах ёстой.	Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 38.2.4 дүгээр заалт, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны цахим хуудсанд банкны эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээллийг мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	ТУЗ-ийн дарга, гишүүд, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын мэдээллийг банкны цахим хуудсанд мэдээлсэн байдал
3	Дотоод хяналтын тогтолцоо	1.0	Банкны цахим хуудсанд үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлж, гарсан өөрчлөлтийг тухай бүр тусгаж байх.	Банкны тухай хуулийн 38.2.3, 38.2.5 дахь заалтууд, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны цахим хуудсанд үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	Үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналтын тогтолцоо зэргийг мэдээлсэн байдал
4	Засаглалын тогтолцоо	1.0	Банк болон групп компанийн засаглалын зарчим, эрсдэлийн удирдах бодлого, стратегийн талаар цахим хуудсанд мэдээлсэн байх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны засаглал болон эрсдэлийн бодлого түүний хэрэгжилтийн үйл явцыг банкны цахим хуудсанд мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	Засаглалын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын бодлого түүний хэрэгжүүлэх үйл явцын талаар мэдээлсэн эсэх
5	Санхүүгийн тайлангийн тайлагнал	1.0	Банкны жил, улирлын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажсан тайлан, банкны ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар баталгаажуулсан жилийн ажлын тайлан зэргийг тогтмол толилуулж байх	Банкны тухай хуулийн 38.1, 38.2.1 дэх заалтууд, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны жил, улирлын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажсан тайлан, банкны ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар баталгаажуулсан жилийн ажлын тайланг банкны цахим хуудсаар мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	Банкны жил, улирлын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажсан тайлан, банкны ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар баталгаажуулсан жилийн ажлын тайланг тогтоосон хугацаанд мэдээлсэн байдал

6	Хэлцэлийн талаар толилуулах	1.0	Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний тайлан, Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг банкны цахим хуудсанд тогтмол толилуулаж байх. Мөн банкны тухайн жилд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийгэд мэдээлэх үүрэгтэй. Их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийгэд мэдээлэх үүрэгтэй	Банкны тухай хуулийн 38 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 89.5, 88.4 дэх заалтууд, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний тайлан, Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг банкны цахим хуудсаар мэдээлсэн эсэх	2	1.0	2	1.0	Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний тайлан болон Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг улирал бүр, их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг банкны жилийн тайланд тусгаж олон нийгэд мэдээлсэн байдал
7	Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээлэх	1.0	Банкны цахим хуудсанд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийг үнэн зөв, бүрэн бүтэн тусгасан эсэх	Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Банкны цахим хуудсанд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийг үнэн зөв, бүрэн бүтэн тусгасан эсэх	2	1.0	2	1.0	Холбогдон гарсан шийдвэрийн огноо, дугаар
8	Нийгмийн хариуцлага	1.0	Жилийн тайланд банкны нийгмийн хариуцлагын талаар тусгасан байх	IFC экватор зарчим, GRI индекс, Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам, зөвлөмж	Жилийн тайланд компанийн нийгмийн хариуцлагын талаар тусгасан эсэх	2	1.0	2	1.0	Банкны зүгээс нийгмийн хариуцлагын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүнээс Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой тжсгасан эсэх
		8.0					8.0		8.0	